

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН АЗИ, НОМХОН  
ДАЛАЙН БҮСИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ,  
ХЭРЭГЖИЛТИЙН ЦАГ УУРЫН АЖЛЫН ДЭД ХЭСГИЙН 23-Р ХУРАЛ  
/APANPIRG 23/-Д ОРОЛЦСОН ТУХАЙ ТАЙЛАН**

2019.06.24

Тайландын Вант Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан Ази, номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын дэд хэсгийн 23-р хурал /APANPIRG 23/-д Нислэгийн цаг уурын төвийн Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Болормаа 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрүүдэд оролцлоо.

Ази, номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын дэд хэсэг нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ОУИНБ/-аас цаг уурын үйлчилгээний бодлого, төлөвлөгөөг тус бүсэд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бүс нутгийн агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж буй цаг уурын хөгжлийн хандлага, бодлогыг нэгтгэх, цаг уурын үйлчилгээг нэгдмэл нэг болгох зорилгоор хуралддаг болно.

Энэ удаагийн хуралд Австрали, Бутан, Хятад, Хонг Конг Хятад, Макао Хятад, Индонез, Япон, Лаос, Малайз, Бүгд Найрамдах Фижи улс, Соломоны арлууд, Монгол, Шинэ Зеланд, Филиппин, Өмнөд Солонгос, Сингапур, Тайланд, АНУ, Вьетнам зэрэг 19 улс, Олон улсын байгууллага (IFALPA)-ын нийт 48 төлөөлөгч оролцлоо. Хурлыг Ази, Номхон далайн бүсийн захирал Арун Мишрагийн нэрийн өмнөөс хурлын дарга Mr. Jun Ryuzaki болон Mr. Peter C. Dunda нар нээж үг хэллээ. Тус хурлыг Mr. Jun Ryuzaki даргалж Mr. Peter C. Dunda нарийн бичгийн даргаар тус тус удирдан явуулсан.

Хурлаар 8 чиглэлээр 40 гаруй асуудал / 29 (WPs), 23 (IPs)/ хэлэлцсэн бөгөөд Монгол улсын төлөөлөгчид нисэхийн цаг уурын чиглэлээр хийгдсэн ажлын талаарх 2 мэдээлэх хуудсыг (IPs) хуралд танилцуулсан болно. Хурлын үеэр агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж буй цаг уурын чиглэлээр хийгдэж байгаа ажлуудтай уялдаа, холбоотой үйл ажиллагаандаа нэн түрүүнд тусгавал зохих дараах асуудлууд яригдлаа. Үүнд:

1. Өмнөх дэд хурлаар хэлэлцсэн асуудлууд болон APANPIRG 29 дүгээр хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийн талаар хэлэлцсэн.
2. ANNEX-3-ын 79 дэх нэмэлт өөрчлөлт нь 2018 оны 10 дугаар сарын 5-нд хүчин төгөлдөр болж 2020 оны 11 дүгээр сарын 5-наас хэрэгжиж эхлэнэ. Иймд Улс орнуудын хувьд энэ тал дээр ямар нэг дэмжихгүй буюу зөрүүтэй санал байвал 2018 оны 7 сарын 16-наас өмнө ОУИНБ-д, Electronic Filing of Differences (EFOD) System-д 2018 оны 10 сарын 5-наас өмнө мэдэгдэх шаардлагатай байгааг мэдээлсэн.
3. Ази Номхон далайн Air navigation plan (ANP) Volume I болон II боть-дахь Table MET-д болон ROBEX handbook-д нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэн улс орнууд өөр өөрсдийн орны мэдээллүүдээ нягталсан.

4. Нисэхийн цаг уурын үйлчилгээ, мэдээлэл солилцоонд IWXXM (ICAO Meteorological Information Exchange Model) загварыг 2018 оноос туршилт хийгдэж 2020 оны 11 дүгээр сарын 5- ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх болсонтой холбогдуулан тус загварыг турших төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг хангаж ажиллах.

Цаг уурын мэдээ солилцоонд IWXXM (ICAO Meteorological Information Exchange Model) загварыг туршиж эхэлсэн улс орнуудын туршлага болон цаашид үүнтэй холбоотой бэлтгэл ажлыг хэрхэн хангуулах талаар ОУИНБ-аас Workshop зохион байгуулахаар шийдвэрлэсэн ба үүнд улс орнуудыг идэвхтэй оролцохыг уриалсан. Мөн 2020 оноос цаг уурын үйлчилгээнд Сансрын цаг уурын мэдээгээр хангах болсон тул тус мэдээлийг хэрхэн урьдчилан мэдээлэх, солилцох талаар бусад орны туршлага судлах.

5. 2018 онд ОУИНБ-аас зохион байгуулж буй бүсийн SIGMET мэдээний тестэнд улс орнуудын оролцож буй оролцоог болон зарим улс өмнөх онуудаасаа идэвхтэй оролцож сайжирсан үзүүлэлттэй байгаа талаарх мэдээллийг хариуцан ажиллаж буй улс орнуудаас өгсөнд хурал даргалагчийн зүгээс талархсанаа илэрхийлсэн болно.
6. Ази Номхон далайн бүсийн Агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын дэд хэсгийн 24-р хурал (MET SG/24)-ыг 2020 оны 7 дугаар сард Тайландын Бангкок хотноо зохион байгуулахаар төлөөлөгчид санал нэгтэй шийдвэрлэлээ.
7. Цаг уурын ажлын хэсгийн өмнөх хурлуудын тайланг сонссон ба тэдгээр ажлын хэсгийн үйл ажиллагаанд бүсийн улс орнууд хэрхэн оролцож байгааг харах боломж гарсан болно. Энэ удаагийн хуралд Монгол улсын хувьд мэдээлэх хуудас 2 IP тавьж, идэвхтэй оролцсон ба манай улсын энэхүү оролцоог хурлын дарга болон нарийн бичгийн дарга нар хурлын үеэр онцлон хэлсэн.
8. Ази, номхон далайн бүсийн агаарын навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн цаг уурын ажлын дэд хэсгийн хуралд хэлэлцэгдсэн асуудлууд, тайлан нь ОУИНБ-ын Агаарын навигацийн хороонд хүргэгдэх ба Ази номхон далайн бүсийн улс орнуудын агаарын навигацийн төлөвлөлт хэрэгжилтийн /APANPIRG 30/-аар хэлэлцэх юм байна. Иймд /APANPIRG 30/ хуралд оролцох төлөөлөгчид нь энэ хурлын тайлан, шийдвэрүүдтэй танилцсан байх шаардлагатай юм.
9. Ажлын дэд хэсгийн хуралдааны үеэр БНХАУ-ын төлөөлөгчидтэй уулзаж хоёр улсын хооронд тулгамдаж байгаа асуудлууд хамтран ажиллах гэрээ байгуулах асуудлаар санал солилцлоо. БНХАУ-ын тал нь Монгол улсын цаг уурын талаар тулгамдаж буй хүндрэлтэй буй асуудлыг шийдэх зорилгоор тусламж дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, хоёр талт гэрээнд цаг уурын байгууллагын төлөөлөгчдийг урьж оролцуулж цаашид хамтран ажиллах талаар санал тависан болно. ОУИНБ-аас цаг агаарын мэдээ солилцох IWXXM форматыг 2020 оноос эхлэн хэрэглэх шаардлага тавигдаж байгаа ба өнөөгийн байдлаар Улаанбаатарын TAF, METAR мэдээнүүдийг Бээжингийн ROC-т OPMET-Flight Information System буюу нислэгийн мэдээлэл үйлчилгээний ажлын цогц программ хангамжаар хүлээн авч байгаа ОУИНБ-аас стандарт шаардлагын

хүрээнд IWXXM форматыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд Монгол улсын цаг уурын байгууллага энэ ажлыг хэрэгжүүлэх ямар төлөвлөгөөтэй ажиллаж байгаа талаар тодорхой мэдээлэл өгөхийг хүссэн. Манай талаас IWXXM-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, Монголын мэргэжилтнүүдийг Бээжингийн Нислэгийн цаг уурын төвтэй танилцуулж туршлага солилцох боломж олгохыг хүссэн болно. Уулзалтын үеэр ярилцсан асуудлуудыг цаашид хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөнд тусгах, ИНЕГ, ЦУОШГ-тай хэлэлцэж, цаашид тохирсон асуудлуудыг ажил хэрэг болгон ажиллахаар тогтов.

10. Нислэгт аюултай цаг агаарын үзэгдэл /аадар бороо, шороон шуурга гэх мэт/ ажиглагдах үед цаг агаарын мэдээлэл харилцан солилцоход хамтран ажиллах, Азийн агаарын навигацийн цаг агаарын аюултай үзэгдлийн зөвлөх платформыг байгуулах талаар ярилцлаа.

Эцэст нь дүгнэхэд, Ази номхон далайн бүсийн улс орнуудын агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж буй цаг уурын чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаатай танилцаж Монгол улсын хувьд дээрх төсөл хөтөлбөрүүдэд оролцох, тухайн бүс нутгийн улс орнуудтай харьцуулах, туршлага судлах боломжийг бүрдүүлсэн, цаашдын бодлого, төлөвлөгөөг сайжруулахад маш том түлхэц өгсөн ач холбогдолтой хурал боллоо.

Тайлан бичсэн:

Мэдээлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Болормаа